

# СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2016 ОНЫ 5 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ

## Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

### **1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:**

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид 1 удаа хуралдаж 8 асуудал хэлэлцэн 6 тогтоол батлав. Үүнд:

- "Сэлэнгэ барилга захиалагч" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын шинэчилсэн дүрмийг баталлаа. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 49 дүгээр тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан "Сэлэнгэ барилга захиалагч" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийг хүчингүй болсонд тооцлоо.

- Хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарт олон жил идэвх зүтгэлтэй ажиллаж газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж, Алтанбулаг сумын "Чагтай" ХХК-ийн захирал Жалсрайн Баярмагнайг "Монгол улсын Гавьяат агрономич" цолоор шагнуулахаар Монгол улсын Ерөнхийлөгчид уламжиллаа.

- Сум орон нутаг, иргэдээс ирүүлсэн хүсэлтийг судлан үзэж Сүхбаатар сумын Баянханы 4 дүгээр багт үйл ажиллагаа явуулж байгаа Буддын шашны "Төгс баясгалант номын хүрд" хийдийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хугацааг 3 жилийн хугацаагаар сунгалаа.

- Сум орон нутаг, иргэдээс ирүүлсэн хүсэлтийг судлан үзэж Орхонтуул суманд үйл ажиллагаа явуулж байгаа Христийн шашны "Орхонтуул эзний хайр" сүмийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хугацааг 3 жилийн хугацаагаар сунгав

- Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны төлөвлөгөөг батлан, санхүүгийн хяналт шалгалтын үйл ажиллагааны тайланг хэлэлцэж, үнэлэлт дүгнэлт өгч ажиллах үүрэг бүхий Дотоод аудитын хороог аймгийн Засаг даргын дэргэд байгуулав.

- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2012-2016 оны бүрэн эрхийн хугацааны үйл ажиллагааны хаалтын хүндэтгэлийн хуралдааныг 2016 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 11.00 цагт аймгийн төвд товлон хуралдуулахаар тогтлоо.

### **2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:**

Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудад Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын тухай хуулийн хэрэгжилт, Олон Улсын стандартын нэвтрэлтийн түвшинг тодорхойлох, анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн програм хангамжийн ашиглалтанд үнэлэлт дүгнэлт өгөх, мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх зорилгоор нягтлан бодох бүртгэлийн үзлэгийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр 2016 оны 5 дугаар сарын 02-оос 6 дугаар сарын 02-ны хооронд аймгийн хэмжээнд зохион байгуулж байна.

2016 оны 5-р сарын 15-ны Зуны эхэн сарын шинийн 15-ний дашнямтай билэгт сайн өдрийг сонгон аймгийн төв Сүхбаатар суманд Сэлэнгэ аймгийн ард түмэндээ зориулж "Сэлэнгэ Олон Улсын Худалдааны төв", "Төрийн үйлчилгээний нэгдсэн төв"-ийн нээлтийн үйл ажиллагааг хамтатган зохион байгууллаа. Энэхүү Олон улсын худалдааны төв ашиглалтанд орсноор нийт 300 гаруй иргэнтохилог ажлын байртай болохоос гадна Төрийн үйлчилгээний нэгдсэн төв байрлаж иргэд, хөдөлмөрчдөд нэгдсэн цогц үйлчилгээг үзүүлэх ач холбогдолтой байна.

Монгол Улсын засгийн газрын 2015 оны 439 тоот тогтоолоор Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогыг эхлүүлэх зорилгоор

2016 оны 05 дугаар сарын 05-ны өдөр Сангийн яам, аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Орон нутгийн өмчийн алба, хамтран аймгийн төсөвт байгууллагын дарга, нягтлан бодогч нарт сургалт зохион байгууллаа.

Төрийн албаны мэргэшлийн шалгалтыг 2016 оны 05 дугаар сарын 09-12-ны өдрүүдэд Төрийн албаны зөвлөлтэй хамтран цахим хэлбэрээр зохион байгуулж, төрийн захиргааны 20 албан тушаалын сул орон тоо зарлагдсанаас 10 албан тушаалын ажлын байранд 212 хүн бүртгүүлж 67 хүн тэнцэж төрийн жинхэнэ албанд анх орох иргэдийн нөөцийн жагсалтад бүртгэгдэхээр боллоо.

Төрийн тусгайлсан албаны ажилтан, албан хаагчдын мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх зорилгоор “Сэлэнгэ-2016” команд штабын сургуулийг Алтанбулаг сумын “Буур хээр”-ийн талд 06 дугаар сарын 17-19-ний өдрүүдэд зохион байгуулж, Хууль зүйн яамны сайд Д.Дорлигжав өөрийн биеэр хүрэлцэн ирж оролцоо. Тус сургалтаар онцгой нөхцөл байдал үүссэн үед Сэлэнгэ аймаг дахь тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын харилцан ажиллагааг бэхжүүлэх, бэлэн байдалд хэрхэн байх нөхцлийг энэ сургуулиар харууллаа.

2016 оны 05 дугаар сарын 05-ны өдөр сумдын Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн албаны дарга нарт 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан, цаашид авах арга хэмжээ, аймгийн орлогын биелэлт, төрийн сангийн дотоод хяналтын хэрэгжилт, цаашид авах арга хэмжээ, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар Санхүүгийн албаны үйл ажиллагаанд чиглэл хүргүүлэх талаар сургалт явуулсан.

Сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ болон Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах талаар чиглэл хүргүүлсэн

Дээрх чиглэлээр хэлтсийн мэргэжилтнүүд хяналт тавьж байгаа бөгөөд 5-р сард Спарк мессенжерт дунджаар 12 сумдын мэргэжилтнүүд онлайн байсан байна. Спаркад өөрчлөгдсөн солигдсон хэрэглэгчдийн судалгааг төсвийн мэргэжилтэн шинэчлэн Сангийн яамны Мэдээлэл технологийн газарт хүргүүлж хэрэглэгчдийн нэрсийг засуулсан.

2016 оны 1-р ээлжийн цэргийн жинхэнэ албаны татлагыг зохион байгуулах

Дэлхийн банк, Швейцарын хөгжлийн агентлагаас “Нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх” нь төслийг Сэлэнгэ аймагт хэрэгжүүлэхээр шийдвэрлэж, аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран эрүүл мэнд, боловсролын салбарт ажиллаж ажилчдын төлөөллүүдэд сургалт зохион байгуулж, тулгамдаж буй шийдвэрлэх шаардлагатай асуудлуудаа тодотголоо.

Сэлэнгэ аймгийн Шаамар, Зүүнбүрэн, Цагааннуур, Түшиг чиглэлийн 145 км хатуу хучилттай автозамын төслийн зам барилгын ажлын нээлт 2016 оны 05 дугаар сарын 14-нд боллоо. Энэхүү хатуу хучилттай автозамын зургийн ажлыг “Мон Аз” ХХК, зам барих ажлыг “Монгол ЛЗ зам гүүр” ХХК хийж гүйцэтгэнэ.

Германы Олон Улсын Хамтын ажиллагааны нийгэмлэгийн Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачлага хөтөлбөрөөс Сэлэнгэ, Баянхонгор, Өвөрхангай, Увс аймагт хэрэгжүүлж буй “Орон нутгийн цогц хөгжил-түншлэл” төслийн хүрээнд зохион байгуулагдаж байгаа төрийн албан хаагчдыг чадавхжуулах ээлжит сургалт “Орон нутгийн төрийн захиргааны өөрчлөлт, шинэчлэлт, боломж ба сорилтууд” сэдвийн дор 2016 оны 5-р сарын 05, 06-ны өдрүүдэд Баянхонгор аймагт зохион байгуулагдлаа. Тус арга хэмжээнд Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга “Төрийн захиргааны шинэчлэл Сэлэнгэ аймагт” сэдвээр илтгэл, мэдээлэл хийж, “Орон нутгийн цогц хөгжил-түншлэл” төслийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаарх хэлэлцүүлэгт аймгийн Засаг даргын Тамгын газрын төрийн албан хаагчдын төлөөлөл амжилттай оролцоод ирлээ.

Аймгийн Засаг даргын 2016 оны А/93 тоот захирамжийн дагуу ажлын хэсэг байгуулагдан аймгийн нутаг дэвсгэр дэх сүм хийдийн үйл ажиллагааг шалган

танилцаж, бүртгэл судалгааг шинэчлэх ажлыг зохион байгуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд дүнг танилцууллаа. Тэргүүлэгчдийн хурлаас зөвшөөрөлгүй ажиллаж байгаа сүм хийдийн үйл ажиллагааг зогсоох, холбогдох хууль, журмын дагуу зөвшөөрөлтэй ч улсын бүртгэлд хуулийн этгээдээр бүртгүүлээгүй шашны байгууллагад зөрчлөө арилгах шаардлага хүргүүлэх зэргээр ажиллахыг аймгийн Засаг даргад даалгалаа.

Аж үйлдвэрийн яам, Гадаад хэргийн яам, Алтанбулаг худалдааны чөлөөт бүсийн захиргаа, аймгийн Засаг даргын Тамгын газар, Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтарсан “Алтанбулаг экспо-2016” үзэсгэлэн худалдаа, “Эдийн засаг, хөрөнгө оруулалтын чуулга уулзалт”-ыг зохион байгуулан, үзэсгэлэн худалдаанд Сэлэнгэ аймгаас 20 аж ахуйн нэгж оролцож 42 сая төгрөгийн борлуулалт хийлээ.

#### **Бусад ажлын талаар:**

#### **Онцгой байдлын газар:**

Эрүүл мэндийн байгууллагууд болон үзвэр үйлчилгээ, соёл урлагийн байгууллагуудад гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль, дүрэм, норм, стандартын хэрэгжилтийг 35 объект, аж ахуйн нэгж, байгууллагуудад гамшгаас урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, 140 зөрчил илрүүлж, зөрчлийг арилгуулахаар гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 17, мэдэгдэл 5, ажиллагаа зогсоох тогтоол 3, дүгнэлт 2-ийг үйлдэж хууль тогтоомж, дүрэм, журам зөрчсөн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн шаардлагыг хэрэгжүүлээгүй 1 ажахуйн нэгж, байгууллагыг 1.920.000, 1 иргэнийг 5000 төгрөгөөр торгож нийт 1.925.000 төгрөгийн захиргааны арга хэмжээ ногдууллаа.

#### **Стандартчилал хэмжил зүйн хэлтэс:**

Монгол Улсын Засгийн газраас зарласан “Хэрэглэгчийн жил”-ийн хүрээнд Цагааннуур, Баянгол суманд “Хэрэглэгч таны төлөө” өдөрлөг зохион байгууллаа. Тус арга хэмжээний хүрээнд “Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хууль”, Худалдааны газрын стандарт, хэмжилзүйн баталгаажуулалтын талаар тус тус мэдээлэл өгч, танин мэдэхүйн “АХА” тэмцээн зохион байгуулан, гарын авлага сургалтын материал тарааж, хэрэглэгчийн санал асуулга авлаа.

2016 оны 05 дугаар сарын 20 “Дэлхийн хэмжил зүйн өдөр” болон “Газрын тосны салбарын ажилтны өдөр”-ийг тохиолдуулан аймгийн Стандартчилал хэмжил зүйн хэлтсээс Газрын тосны газрын Сэлэнгэ дэх төлөөлөгчтэй хамтран Сүхбаатар сумын шатахуун түгээх газрын ажилтнуудад “Динамик ертөнцийн хэмжил” сэдэвт арга хэмжээ зохион байгууллаа. Арга хэмжээний үеэр “Шатахуун түгээх станц MNS 4628-2013” стандарт, “Баталгаажуулалт, шатахуун түгээх газрын баталгаажуулалт, хэмжих хэрэгслийн тухай, “Газрын тосны газрын үйл ажиллагааны тухай” зэрэг сэдвүүдээр мэдээлэл өгчлөө.

Сүхбаатар, Баянгол, Мандал, Алтанбулаг, Түшиг, Цагааннуур, Зүүнбүрэн, Шаамар сумдын 60 худалдаа үйлчилгээний газруудад тохирлын үнэлгээ хийж, сумдын баталгаажуулалтын орон тооны бус салбар зөвлөлийн хурлын шийдвэрээр худалдаа, үйлчилгээний газрын мөрдвөл зохих стандартын 84,0-өөс дээш хувийг хангасан 49 худалдаа, үйлчилгээний газарт, тохирлын гэрчилгээ олголоо.

Мандал, Түшиг, Орхонтуул, Шаамар, Сүхбаатар сумын 5 аж ахуйн нэгж, иргэний 4 нэрийн 6 бүтээгдэхүүнийг Мэргэжлийн хяналтын газрын итгэмжлэгдсэн сорилтын лабораторит сорилт шинжилгээнд хамруулж баталгаажуулалтын шинжээчийн дүгнэлт гаргалаа.

“Спирт Бал Бурам” ХХК-ийн архины үйлдвэрт “Согтууруулах ундааны үйлдвэрлэлийн техникийн зохицуулалт MNTR 1:2008”, “Согтууруулах ундаа, Цагаан болон өвөрмөц архи, Техникийн ерөнхий шаардлага MNS 179:2009”

стандартын дагуу тохирлын үнэлгээ хийж “Evok, Viva, Титэм, Сүлд” нэрийн 4 төрлийн цагаан архинд тохирлын гэрчилгээ олголоо.

Шаамар, Зүүнбүрэн, Түшиг, Цагааннуур, Баянгол, Мандал сумын худалдаа, үйлчилгээ эрхлэгч аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа 103 жин, 8 туухай нийт 111 хэмжих хэрэгсэл баталгаажууллаа.

**Хоёр.Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:**

**1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:**

4-р сарын 30-ны байдлаар

/мянган төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Орон нутгийн төсвийн нийт орлого	5,649,449.3	4,812,086.9	85.2
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	4,444,050.3	3,953,293.2	89.0
2	Орон нутгийн төсвийн нийт зарлага	24,730,194.9	20,995,088.4	84.9
	Үүнээс: Аймгийн төсвийн зарлагын дүн	6,268,478.4	4,674,185.3	74.6
	- Аймгийн ОНХСангийн зарцуулалт	501,742.8	203,262.1	40.5
	- Аймгийн авто замын хөрөнгө оруулалт	296,756.8	101,928.6	34.3
	- Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	451,489.7	173,712.4	38.5
3	Улсын төсвөөс олгосон ОНХСангийн орлогын шилжүүлэг	1,023,629.6	1,249,928.6	122.1
4	Улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг	1,138,200.0	1,138,200.0	100.0
5	Улсын төсвөөс олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	14,849,191.2	14,849,191.2	100.0
	- Ерөнхий боловсролын сургууль	7,458,194.9	7,458,194.9	100.0
	- Хүүхдийн цэцэрлэг	3,968,544.2	3,968,544.2	100.0
	- Эрүүл мэнд, спортын байгууллага	2,196,021.6	2,196,021.6	100.0
	- Соёлын байгууллагуудын	1,050,285.5	1,050,285.5	100.0
	- Газрын харилцаа кадастрын алба	72,528.7	72,528.7	100.0
	- Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэс	103,616.3	103,616.3	100.0
6	Төсвийн байгууллагуудад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	14,849,191.2	14,849,191.2	100.0
	- Ерөнхий боловсролын сургууль	7,458,194.9	7,458,194.9	100.0
	- Хүүхдийн цэцэрлэг	3,968,544.2	3,968,544.2	100.0
	- Эрүүл мэнд	1,701,784.2	1,701,784.2	100.0
	- Өрхийн эмнэлэг	183,582.0	183,582.0	100.0
	- Спортын байгууллага	310,655.4	310,655.4	100.0
	- Соёлын байгууллагуудын	1,050,285.5	1,050,285.5	100.0
	- Газрын харилцаа кадастрын алба	72,528.7	72,528.7	100.0
	- Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэс	103,616.3	103,616.3	100.0
7	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	1,247,089.8	1,247,089.8	100.0
8	Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	614,177.7	614,177.7	100.0
9	Аймгийн нийт ангилагдаагүй зардал	264,254.9	181,835.7	68.8
10	Үүнээс: Аймгийн Засаг даргын нөөц	150,000.0	97,721.2	65.1

**2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:**

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл	2016	2016	2016-IV
	III- сар	IV- сар	2016-III
<b>1.ХҮНСНИЙ БАРАА</b>			

<b>1</b>	Талх, гурил, будаа			
	Гурил /савласан, кг/	1200	1200	100
	Талх /орон нутгийн, ш/	1100	1100	100
	Нарийн боов /кг/	2300	2300	100
	Будаа /кг/	2200	2200	100
	Элсэн чихэр /кг/	1800	1800	100
<b>2</b>	<b>МАХ МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН</b>			
	Хонины мах /кг/	5500	6500	118.2
	Үхрийн мах /кг/	7200	8200	113.9
	Адууны мах /кг/	4500	5500	122.2
	Ямааны мах /кг/	5000	6000	120.0
	Дотор мах, цувдай /цусгүй/	3500	4000	114.3
	Хиам /чанасан, кг/	9500	9500	100.0
<b>3</b>	<b>СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ</b>			
	Сүү /задгай, л/	1300	1200	92
	Сүү / савласан, л/	2500	2500	100
	Тараг /задгай, л/	1500	1500	100
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	10000	10000	100
	Айраг /л/	3500	3500	100
	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	4000	4000	100
	Өндөг /ш/	300	300	100
<b>4</b>	<b>БҮХ ТӨРЛИЙН ӨӨХ ТОС</b>			
	Ургамлын тос /л/	3400	3400	100
	Өөхөн тос /кг/	1500	1500	100
	Шар тос /кг/	9000	9000	100
	Масло /задгай, кг/	5000	5000	100
<b>5</b>	<b>ХҮНСНИЙ НОГОО</b>			
	Төмс /кг/	1000	1000	100
	Лууван /кг/	2000	2000	100
	Манжин /кг/	2000	2000	100
	Байцаа /кг/	2000	2000	100
	Сонгино /кг/	2000	2000	100
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	3000	3000	100
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	2500	2500	100
<b>2</b>	<b>ШАТАХУУН</b>			
	Бензин А - 80	1480	1480	100.0
	Бензин А - 92	1580	1580	100.0
	Дизелийн түлш	1690	1690	100.0

### **Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:**

Аймгийн хэмжээнд энэ оны 4 дугаар сард бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гэмт хэрэг 268 буюу 1,1 хувиар өссөн, учирсан хохирол /сая.төг/ 450.0 буюу 25.1 хувиар буурсандүнтэй байна.

Гэмт хэргийн төрлөөр нь авч үзвэл:

- Хүнийг санаатай алах хэрэг 2 бүртгэгдэж 2 дахин өссөн
- Бусдыг амиа хорлоход хүргэх 9 буюу 30.8 хувиар буурсан
- Бусдын бие махбодид гэмтэл учруулах 108 буюу 21.3 хувиар өссөн
- Хүчиндэх 7 буюу 6 дахин буурсан

- Хулгайлах 70 буюу 16.6 хувиар буурсан
- Хувийн өмчийг хулгайлах 43 буюу 20.4 хувиар буурсан
- Мал хулгайлах 27 буюу 6.9 хувиар буурсан
- Дээрэмдэх 4 буюу 2 дахин өссөн
- Эм бэлдмэл, бодис хууль бусаар тээвэрлэх хэрэг 1 бүртгэгдэж 1 дахин
- Ойн хууль тогтоомж зөрчих гэмт хэрэг 12 бүртгэгдэж 6 дахин өссөн
- Хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг 18 буюу 5.9 хувиар өссөн байна.

### **Архивын талаар:**

Төрийн архивын улсын үзлэгийн бэлтгэл ажлыг эрчижүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан аймгийн Засаг даргын Тамгын газрын даргаар баталгаажуулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Бүрдэл хангасан дансуудыг хурлын тэмдэглэлтэй тулгаж гарын үсэг, тамга тэмдэг дутуу дансны судалгааг гарган, 2014, 2015 онуудад хэсэгчилсэн тооллого хийсэн тухай актыг хөмрөгийн хувийн хэрэгт хавсаргалаа.

AMS программд Бургалтай сангийн аж ахуйн хөмрөгийн 32 хадгаламжийн нэгжийн 5423 хуудасны баримтын мэдээллийг уншиж заалт 3897, хүний нэр 28956, байгууллагын нэр 331, газарзүйн нэр 357-г шивж ашиглалтын хувьтай холбох ажлыг хийж гүйцэтгэлээ.

Бургалтай сангийн аж ахуй, Шүдэнзний үйлдвэрийн хөмрөгийн нийт 39 хадгаламжийн нэгжийн 6855 хуудсыг Photoshop программ ашиглан засварлаж ашиглалтын хувь үүсгэлээ.

Зүүнхараагийн Мод бэлтгэлийн аж ахуйн хөмрөгийн 13 хадгаламжийн нэгжид эрдэм шинжилгээ, техник боловсруулалтын ажлыг хийж 2157 хуудсыг скайнердаж мастер хувь үүсгэн шинээр хавтаслаж хөмрөгт байрлууллаа.

Албан байгууллага, иргэдийн хүсэлтийн дагуу давхардсан тоогоор нийт 50 гаруй иргэнд үйлчилж архивын хуулбар 46, магадлагаа 4, тодорхойлолт 2, гарган үйлчиллээ.

### **Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:**

#### **1. Боловсролын чиглэлээр:**

Аймгийн Боловсрол, соёлын газар, Мандал сумын улсын тэргүүний Нархан цэцэрлэгтэй хамтран “Сургуулийн өмнөх боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн хэрэгжилт, түүнд нөлөөлөх сургалтын орчин” сэдэвт үзүүлэх сургалтыг зохион байгуулж, сургалтанд аймгийн нийт хүүхдийн цэцэрлэгийн 160 гаруй багш, удирдах ажилтнууд оролцлоо. Үзүүлэх сургалтаар хүүхдийн сурсан, мэдсэн зүйлийг эцэг эхчүүдэд тайлагнах зорилгоор 420 гаруй хүүхдийн тайлан тоглолт, багш ажилчдын 800 гаруй бүтээлийн тайлан тоглолтыг гаргалаа.

Бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөр хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан энэ хичээлийн жилд 9-р анги төгсөж байгаа сурагчдад “Суралцах чиглэл, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сонголтын 7 хоног” үйл ажиллагааг хөтлөн явуулах, анги удирдсан багш нарт арга зүйн зөвлөгөө өгөх сургалт зохион байгууллаа.

БСШУ-ны сайдын 2013 оны А/309 тоот тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон боловсролын чанарын үнэлгээний журам”-ын дагуу 2015-2016 оны хичээлийн жилд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшигчдээс авах улсын шалгалтыг 2016 оны 5-р сарын 25-аас 6-р сарын 2-ны өдрүүдэд зохион байгуулах тул улсын шалгалтын комиссыг сургуулийн захирлын тушаалаар томилж баталгаажуулан, шударга, бодитой зохион байгуулан ажиллахыг үүрэг болголоо.

Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Боловсрол соёлын газартай хамтран “Сэлэнгэ нутгийн бахархал” аяныг 2 дахь удаагаа өрнүүлж дүгнэлээ. Тус аяныг ерөнхий боловсролын 27 сургууль нэгжид

суралцагчдын нас, сэтгэхүйн онцлогийг харгалзан нийтдээ давхардсан тоогоор 16172 хүүхэд, 2251 эцэг эх, асран хамгаалагч, 451 багш ажилчид, 25 төрийн болон төрийн бус байгууллага оролцож, хамтран ажиллалаа. Ерөнхий боловсролын сургуулиуд энэхүү үйл ажиллагааны чиглэл зорилгыг “Зөв монгол хүүхэд” үндэсний хөтөлбөртэй уялдуулан мөн сургалтыг дэмжих үйл ажиллагааны цагийн хөтөлбөрт оруулан хэрэгжүүлсэн нь бүх нийтээр төлөвлөсөн үйл ажиллагааны цагийн хөтөлбөрт оруулан хэрэгжүүлсэн нь бүх нийтээр төлөвлөсөн үйл ажиллагаагаа амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг боллоо.

## **2. Нийгмийн даатгалын талаар:**

2016 оны 05 дугаар сарын 25-ны байдлаар аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь сангуудад 8198.2 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл оруулах төлөвлөгөөтэйгээс 8648.9 сая төгрөг хуримтлуулж, төлөвлөгөөний биелэлт 105.5 хувьтай байна.

Тэтгэвэрийн даатгалын сангаас 14832 тэтгэвэр авагчдад 15.9 тэр бум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын сангаас 2144 даатгуулагчдад 634.9 сая төгрөгийн хөдөлмөрийн чадвар түр алдалт, жирэмсэн амаржсаны, оршуулгын тэтгэмжийг тус тус олголоо.

Үйлдвэрлэлийн осол, мэргэшлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас 263 даатгуулагчид 367.3 сая, төгрөгийн тэтгэвэр, үйлдвэрлэлийн ослын тэтгэмж, ажилгүйдлийн даатгалын сангаас 234 даатгуулагчид 323.7 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж олголоо.

2016 оны 05 сард өссөн дүнгээр 29 ажил олгогч, шинээр бүртгэж 40 даатгуулагчийг албан журмын даатгалд хамрууллаа.

## **3. Нийгмийн халамжийн үйлчилгээний талаар:**

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2647 иргэнд 280.02 сая төгрөг, нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмжинд 1630 иргэнд 47.7 сая төгрөг, ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламжинд 340 иргэнд 57.6 сая төгрөг, амжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламжинд 840 иргэнд 57.04 сая төгрөгийг тус тус олголоо.

Хөгжлийн бэрхшээлтэй 112 иргэнд 21.2 сая төгрөгийн тусламж, хөнгөлөлт үйлчилгээг, жирэмсэн, хөхүүл нярай хүүхэдтэй 2753 эхэд 91.2 сая төгрөг, алдар цолтой ахмадуудад үзүүлэх хөнгөлөлт, тусламж үйлчилгээнд 48 иргэнд 6480.0 мянган төгрөгийг тус тус олголоо.

Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд 106 иргэнд 10.8 сая төгрөгийн туслалцааг үзүүллээ.

## **4. Хөдөлмөр эрхлэлтийн талаар:**

2016 оны 04-р сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэд 1009 байсан бол 115 иргэн шинээр бүртгүүлж ажил олгогчоос ирүүлсэн 112 ажлын байранд 90 хүнийг ажилд зуучилж, идэвхигүйн улмаас 77 иргэн хасагдаж бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 957 боллоо.

Аж ахуй эрхлэх, бичил бизнесийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд санхүүгийн дэмжлэгт хамрагдахаар ирүүлсэн төслүүдээс 14 сум 5 тосгоны 71 иргэнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 96640.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг үзүүлэн 71 ажлын байрыг шинээр бий болгоод байна.

Мөн хөтөлбөрийн бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах арга хэмжээнд газрын асуудлаа шийдвэрлэсэн 13 сум 4 тосгоны 18 бүлэгт төмс хүнсний ногооны үр бордоо, тоног төхөөрөмж худалдан авах, хашаа хайс барих, бусад үйл ажиллагааны зардалд нийтдээ 52000.0 мянган төгрөгийг зарцуулан 55 иргэнийг улирлын чанартай ажлын байраар хангаад байна.

Нийтийг хамарсан ажлын хүрээнд 17 сум 6 тосгоноос ирүүлсэн 62 саналаас нэн шаардлагатай зам засвар, мод тарих, хог хаягдалыг цэвэрлэх, ойн цэвэрлэгээ,



нийтийн эзэмшлийн гудамж талбайг тохижуулах зэрэг 62 төслүүдийг 105600.0 мянган төгрөгний төсөвт багтаан шийдвэрлэн гэрээ байгуулан ажиллаж байна.

Номгон, Сайхан, Ерөө, Сант зэрэг сумдад төв зам сайжруулах, явган хүний гүүр барих, голын ай сав, үерийн далан болон усалгааны шуудуу засах, цэвэрлэх зэрэг 5 ажлын төсөлд бүртгэлтэй ажилгүй 73 иргэнийг түр ажлын байраар хангаж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 12095.2 мянган төгрөгийн цалин олголоо.

Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох, ажлын байр хадгалах хүрээнд Алтанбулаг, Сайхан сумдад тогооч мэргэжлээр 40 иргэнийг, Цагааннуур суманд худалдагч, касс, нярав мэргэжлээр 20 иргэнийг мэргэжил олгох сургалтанд хамруулан суралцуулж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хүрээнд ажил олоход хүндрэлтэй иргэдэд харилцааны ур чадвар эзэмшүүлэх, хөдөлмөрийн харилцааны мэдлэг олгох, хөдөлмөрийн дэг журам, үйлдвэрлэлийн горимд дасан зохицоход нь туслалцаа үзүүлэх зорилгоор Мандал сумын хувиараа хөдөлмөр эрхлэх хүсэлтэй 25 иргэнд “Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох” сургалтыг зохион байгуулж, зөвөлгөө мэдээлэл өгч ажиллалаа.

“Аюулгүй ажлын байр – Амьдралын баталгаа” өдөрлөгийг Мандал суманд зохион байгууллаа. Өдөрлөгт нийт 25 аж ахуй нэгж байгууллага, 200 гаруй иргэд оролцлоо.

#### **5. Хүүхэд залуучуудын талаар:**

Аймгийн Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтэс, Цагдаагийн газар, Боловсрол соёлын газар, Дэлхийн зөн Сэлэнгэ орон нутгийн хөгжлийн хөтөлбөртэй хамтран Хүүхэд хамгааллын сарын аяны хүрээнд нийт 17 сум, 6 тосгон, 50 багт 04 дүгээр сарын 22-ноос 5 сарын 22-ны өдрийг хүртэл сумдын Засаг даргын Тамгын газартай хамтран, “Хүүхдийн эрхийн тухай”, “Хүүхэд хамгааллын тухай” хуулиудыг орон нутагт сурталчилж, боловсролын салбарыг хүүхэд хамгааллын бодлоготой болгох, эцэг эхчүүдэд хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргыг таниулан сурталчлах, гэр бүлийн эерэг харилцааг нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгууллаа.

Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс Зүүнбүрэн, Шаамар, Алтанбулаг, Сүхбаатар сумдын хүүхэд харах үйлчилгээний үйл ажиллагаатай танилцаж зөвлөн туслах үйлчилгээг үзүүллээ. Аймгийн хэмжээнд 5 дугаар сарын байдлаар 36 иргэн хүүхэд харах үйлчилгээг эрхэлж, 158 хүүхэд хамрагдаж, 15408.9 мянган төгрөгийн санхүүжилтийг олгоод байна.

Аймгийн Хөдөлмөрийн хэлтэстэй хамтран хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн дуу хоолойг төр засаг, олон нийтэд хүргэх, тэдний эрхийг хамгаалах асуудалд багш, эцэг эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгая” аяныг 2016 оны 04 дүгээр сарын 21-ний өдрөөс 06 дугаар сарын 12-ныг хүртэлх хугацаанд зохион байгуулж байна.

#### **6. Биеийн тамирын талаар**

Монгол Улсын гавъяат тээвэрчин Дамбийбалжир агсаны нэрэмжит насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах талбайн хөл бөмбөгийн тэмцээн 2016 оны 05 дугаар сарын 21-22-ны өдрүүдэд аймгийн төв Сүхбаатар суманд зохион байгуулагдаж, Сэлэнгэ, Дархан-Уул аймаг, Улаанбаатар хотын 12 багийн 160 гаруй тамирчид оролцож, Мандал сумын Вагон депо баг тэргүүн байранд шалгарлаа.

2016 оны 04 дүгээр сарын 21-22-ны шилжих шөнө болсон хүчтэй шуурганы улмаас аймгийн цэнгэлдэх хүрээлэнгийн дэвэр нурсантай холбогдуулж, Биеийн тамир спортын газраас 14 хоногийн хугацаанд засварлаж дуусгалаа.

Ахмад волейболчдын аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг Сайхан суманд зохион байгууллаа. Тэмцээнд Сайхан, Орхон, Орхонтуул, Шаамар сумын эмэгтэй 8 баг, эрэгтэй 4 багийн 80 гаруй тамирчид оролцон хурд, хүч авахаалж, самбаагаа сорин өрсөлдлөө.



### **Тав.Үйлдвэр, хөдөө аж, ахуйн бодлогын хүрээнд:**

“Ургамал, түүнийгаралтайхүнснийногоо, түүхийэд, бүтээгдэхүүнийулмөрийгмөрдөнтөгтоохбүртгэл”-ийнжурмыгэнэоны 06 дугаарсарын 01-ний өдрөөсмөрдөжэхлэхээрболсонтойхолбогдууланСэлэнгэаймгийнХүнс, хөдөөажухуйнгазраастөмс, хүнснийногоотариалагчдад тус журмынталаархтанилцуулгыг05 дугаарсарын 20, 21, 22-ны өдрүүдэдСүхбаатар, Сайхан, Мандалзэрэгсумдадбүсчлэнзохионбайгуулж,нийтдээ 300 гаран ногоочингхамруулан 500 ширхэг гарын авлага тараах материалаар хангалаа.

Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас олгосон 6 кг шар манжин, 13 кг хүрэн манжин, 300 кг төл сонгины үрийг аймгийн нийт сумдад хуваарилж, зорилтот бүлгийн иргэдэд тараалаа.

Хүнс, хөдөө аж ахуйн яам, аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар хамтран “Хөдөө аж ахуйн зохистой дадал, бүтээгдэхүүний аюулгүй байдал сургалт”-ыг Мандал, Сүхбаатар, Сайхан суманд зохион байгуулж, 17 сумын 300 гаруй ногоочдыг оролцуулан 500 гарын авлага материалаар ханган ажиллалаа.

“Монгол ногоо” хөтөлбөр, “Ургамал хамгааллын хүрээлэн”-тэй хамтран “Хүлэмжийн аж ахуй эрхлэх, ургамал хамгаалал” сургалтыг Мандал суманд зохион байгуулж, Хушаат, Баянгол, Сайхан зэрэг сумдын 70 гаруй ногоочдыг хамрууллаа.

Энэ онд 676912 эх мал төллөхөөс 05 дугаар сарын 24-ны байдлаар 521348 эх мал төллөж үүнээс ингэ 76, гүү 8083, үнээ 38788, эм хонь 280533, эм ямаа 193868 төллөж бойжиж буй төл 520978 үүнээс хорогдсон төл 1542 төл бойжилт 99.5 хувьтай, нийт мал төлөлт 77 хувьтай байна.

Том малын хорогдол нийт 1941 үүнээс тэмээ 1, адуу 178, үхэр 444, хонь 666, ямаа 657 үүнээс хээлтэгч 398, өвчнөөр 141 бусад нь зүй бусаар хорогдсон мэдээтэй байна.Одоогоор хаваржилт манай аймагт хэвийн тухай бүр холбогдох мэдээллүүдийг авч дээд газарт хүргүүлэн ажиллаж байна.

### **Зургаа. Газрын харилцаа, барилга хот байгуулалтын чиглэлээр:**

#### **1. Газрын харилцааны талаар:**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 52 дугаар тогтоолоор томилогдсон ажлын хэсэг аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хилийн цэсийн эргэлтийнцэгийг солбицолжуулах ажлыг “Глобус” ХХК-тай хамтран зохион байгуулж, ажил гүйцэтгэх явцад тодорхой бус гэж үзсэн хилийн цэсийн эргэлтийн 216 цэгийг газар дээр нь олж тогтоож, зайлшгүй тэмдэглэгээ хийх шаардлагатай 13 сумын хилийн заагт нийт 33 эргэлтийн цэгийг суулгаж тэмдэгжүүллээ

Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй нэр бүхий 4 эзэмшигч, ашиглагч компанийн нийт 1231.71 га газарт 2016 оны уулын ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 10754.240 төгрөгийн газрын төлбөрийг ногдуулан газар эзэмших, ашиглах гэрээг байгууллаа.

Орхон сумаас хог хаягдлаас үүдэн хөрсний бохиролд орсон болон элсний нүүлтэд орсон газруудын нийт 5 нэгж талбарын зургийг хүлээн авч 1:100 000 маштабтай байр зүйн зурагт буулгаж, худгийн 6 цооногийн бүтэц зохиомжийг Газрын харилцаа, геодези зураг зүйн газарт хүргүүллээ.

Аймгийн төв Сүхбаатар суманд одоо эзэмшиж байгаа газраа өмчилж авах хүсэлт гаргасан 13 иргэнд 45.09 сая төгрөгийн үнэ бүхий 13785м<sup>2</sup> газрыг нэг удаа үнэ төлбөргүйгээр өмчлүүллээ.

#### **2. Барилга хот байгуулалтын чиглэлээр:**

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 8-р багт байрлах “Гачуурт” ХХК-ийн 1500 м<sup>3</sup> багтаамжтай түлшний сав,ачиж буулгах байгууламжийн ажил, Баянгол сумын 75 хүүхдийн цэцэрлэг, “Сэлэнгэ таван хан” ХХК-ны гүйцэтгэсэн Зүүнбүрэн сумын

Засаг даргын Тамгын газрын барилгуудад тус тус улсын комисс ажиллаж үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд хүлээлцүүлээ.

Хүдэрсумын ерөнхий боловсролын сургуулийн сургуулийн барилгын сантехник, заалны засварын ажил дээр улсын комисс ажиллаж байнгын ашиглалтанд хүлээлцүүлээ.

Барилгын хөгжлийн төв, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар хамтран Сүхбаатар суманд байрлах 4-р цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, Усан бассейний барилга, ерөнхий боловсролын 6-р сургуулийн өргөтгөлийн барилгад тус тус хяналт хийлээ.

Орхон сумын Ахуйн үйлчилгээний барилгын халаалтын ажлын төсөв, Орхон сумын 42-р зөрлөгөөс Шийр суурин хүртэлх 1.5 км хайрган хучилттай замын ажлын төсөв, Орхон сумын Эрүүл мэндийн төвийн байрны шинэчлэл, засварын ажлын төсвүүдэд Газрын харилцаа барилга хот байгуулалтын газраас хяналт хийн ажиллалаа.

### **Долоо.Сүм орон нутгийн талаар:**

#### **1.Алтанбулаг сум:**

Тус сумын ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн оролцооны боловсролын багаас “Flash mob”бүжгийн тэмцээнийг 2016 оны 05 дугаар сарын 22-ны өдөр зохион байгууллаа.

Сумын Засаг даргын Тамгын газар, Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллагатай хамтран “Медалиа зүүцгээе” арга хэмжээг зохион байгуулж, 2015-2016 оны хичээлийн жилд амжилт гаргасан нийт 74 сурагчийг шагнаж урамшууллаа.

Алтанбулаг сумын эрүүл мэндийн төвөөс “Эрүүл мэндийг дэмжигч ажлын байр” шалгаруулах болзолт уралдааныг 2016 оны 04 дүгээр сарын 11-ээс 05 дугаар сарын 11-ний өдрийг хүртэлх хугацаанд төр, төсвийн байгууллагуудын дунд зарлан, дүгнэх арга хэмжээг зохион байгууллаа.

Тус сумын Соёлын төвөөс “Нийтийн цэнгээнт бүжгийг урлагийн боловсролоор дамжуулан иргэдийг хөдөлгөний дутагдлаас урьдчилан сэргийлэх нь” сарын арга хэмжээг зохион байгуулж, ахмадуудын дунд бүжгийн сургалтыг хийн нийт 40 гаруй ахмад настан хамрагдлаа.

#### **2.Баянгол сум:**

Тус сумын Засаг даргын 2016 оны А/82 тоот захирамжийн хэрэгжилтийг хангаж, 5-р сарын 18-25-ны өдрүүдэд бүх нийтийн хог цэвэрлэгээ зохион байгуулж, суманд үйл ажиллагаа явуулж буй төр төсвийн байгууллага, аж ахуйн нэгжүүд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор мод тарих ажлыг хийлээ.

Баянгол сумын хэмжээнд гэрээр айлчлах хөтөлбөрийн хүрээнд нийт 30 өрх сонгогдсоноос нэн тэргүүнд тусламж шаардлагатай 1 өрхийг амьдрах орчныг нь сайжруулах зорилгоор сумын Засаг даргын Тамгын газар, Дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтран хашаа байшинг нь засварлаж, 3 сая дахь иргэний үе чацуутанд сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас 5 сая төгрөг олгож, бичил уурхай эрхлэгчдээс сайн үйлсийн аян зохион байгуулж, гэрийн дотор засвар чимэглэлийг хийлээ.

“Татвар төлөгчдийн өдөр” арга хэмжээг 2016 оны 05 дугаар сарын 02-13-ны өдрүүдэд зохион байгуулж, иргэдэд хууль тогтоомж сурталчлах, заавар зөвлөгөөг өгөх, гарын авлага материалаар ханган, “Хос түрүү” ХХК-ийн нэрэмжит гарын бөмбөгийн тэмцээнийг зохион байгууллаа.

#### **3.Баруунбүрэн сум:**

Аймгийн Засаг дарга тайлант сард тус суманд ажиллаж сумын иргэд хөдөлмөрчидтэй уулзан 2012-2016 оны үйл ажиллагааны тайлангаа танилцуулж, цаг үеийн ажлын талаар мэдээлэл хийлээ.

Монгол Улсын Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Хүүхэд харах үйлчилгээг эрхлэх нэг иргэнд Хүүхэд харах үйлчилгээний байрны дүгнэлт гарган зөвшөөрөл олгон гэрээ байгуулан ажилласны үр дүнд Бургалтай 2-р багийн иргэн М. Мөнгөн-Эрдэнэ нь Өгөөмөр гэдэг газарт 5 хүүхэд харж байна.

Тус сумын Засаг даргын Тамгын газраас Олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан “Шилдэг гэр бүл2016” арга хэмжээг зохион байгуулж, шилдэг залуу гэр бүлээр Ивэн 1-р багийн иргэн Г.Гантулга, Олон хүүхэд төрүүлж өсгөсөн гэр бүлээр Ивэн 1-р багийн иргэн М.Батмөнх, Бүтээлч гэр бүлээр Бургалтай 2-р багийн иргэн Л.Машбат, Алдартай гэр бүлээр Бургалтай 2-р багийн иргэн Х.Нядсэрэн, Олон жил хамт амьдарсан гэр бүлээр Бургалтай 2-р багийн иргэн Н.Баттогтох нарын гэр бүлийг шалгарууллаа.

Баруунбүрэн сумын Засаг даргын Тамгын газар, Орхон аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын хооронд байгуулсан хамтран ажиллах гэрээний биелэлтийг дүгнэж, цаашид хамтран ажиллах тал дээр ярилцаж, гэрээг шинэчлэн баталлаа.

Аймгийн Хөдөлмөрийн хэлтэс, Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэсээс хамтран зохион байгуулсан Хүүхдийн хөдөлмөрт “үгүй” гэж хэлье - чанартай боловсролд “за” гэж хэлье уриан дор эссэ бичлэгийн уралдаанд Д.Мягмарын нэрэмжит ерөнхий боловсролын сургуулийн 12-р агийн сурагч О.Болортуяа 2-р байр эзэллээ.

#### **4.Ерөө сум:**

Ерөө сумын Засаг даргын тамгын газраас 2016 оны 05 сарын 12- ны өдөр "Хүлээж биш, хүрч үйлчилье" уриан дор 2-р багийнмалчин өрхөөр 10 албан хаагчдынбүрэлдэхүүнтэйгээр ажиллан,төрийн үйлчилгээг хүргэж, албанхаагчид ажил үүргийнхээ дагуу 15 өрхийн 30 малчин иргэдийнсанал хүсэлтийг сонсож, гарынавлага тараах материалаар хангаж, цаг үеийн холбогдолтой мэдээ мэдээллийг хүргэлээ.

Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддагЕрөө бүсийн төрийн албан хаагчдын урлаг, спортын наадам 5 дахь жилдээ Ерөө суманд амжилттай зохион байгуулагдаж, өнгөрлөө. Уг арга хэмжээнд 100 гаруй төрийн албан хаагчид аваалж самбаа, хурд хүчээ сорин өрсөлдлөө.

Сумын Засаг даргын Тамгын газраас “Сонгуулийн тухай” хуулиас төрийн албан хаагчдад холбогдох хориглосон болон хариуцлага хүлээлгэх зүйл, заалтууд, Сонгуулийн тухай хуулийн ойлголт өмнөх хуулиас ялгагдах онцлогийн талаар төр төсвийн байгуулагуудын дунд сар бүрийн сүүлийн долоо хоногийн Нийтийн сонсгол мэдээллийн өдөр буюу 2016 оны 05-р сарын 23 өдөр 41 албан хаагчдад сургалт зохион байгуулж ажиллалаа.

#### **5.Жавхлант сум:**

2016 оны 1-р ээлжийн цэрэг татлагад цэргийн насны 51 залуус хамрагдсанаас 4 цэрэг тэнцэж цэргийн жинхэнэ албанд мордлоо.

Тус сумын Засаг даргын Тамгын газраас “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтыг дээшлүүлье” сэдэвт сургалтыг төрийн албан хаагч нарын дунд явуулж, хөрөнгө оруулалтаар хийгдэх ажил арга хэмжээнүүдийг орон нутагт зохион байгуулах ажлын хэсгүүдийг хуваариллаа.

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “Татвар төлөгч танд баярлалаа” сэдэвт зохион бичлэг, гар зураг, даам, АХА тэмцээнийг зохион байгууллаа.

Аймгийн Хөдөлмөрийн хэлтэс, тус сумын Засаг даргын тамгын газартай хамтран “Мэргэжил сурталчлах өдөрлөг”–ийг зохион байгуулж, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвөөс сумын ажилгүй иргэд болон багш сурагчдад тогооч,

барилгын засвар, засал чимэглэл, гагнуурчин, ойжуулагч, автомашины засварчин мэргэжлээр үзүүлэх сургалт зохион байгууллаа.

Хаврын тариалалт эхэлсэнтэй холбогдуулан “Тариаланчдийн зөвлөгөөн”-ийг зохион байгуулж нийт 13 аж ахуйн нэгж хамрагдлаа. Уг зөвлөгөөнд Ургамал, газар тариалангийн эрдэм, шинжилгээний хүрээлэнгийн эрдэмтэд, аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч нар оролцож, аж ахуйн нэгжүүдийн хөрсний шинжилгээний дүн, цаг үеийн мэдээ мэдээлэл, 2015 оны аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан гэрээгээ дүгнэлээ.

### **6.Зүүнбүрэн сум:**

Тус аймгийн Шаамар, Зүүнбүрэн, Цагааннуур, Түшиг сум хүртэлх хатуу хучилттай авто замын ажлын нээлтийн арга хэмжээг зохион байгуулж, аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат, УИХ-ын гишүүн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Баярцогт, УИХ-ын гишүүн Ж.Эрдэнэбат, аймгийн Засаг дарга С.Бүрэнбат, холбогдох сумдын Засаг дарга нар оролцлоо.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор сумын Засаг даргын Тамгын газраас нийт 29 иргэнийг нэмэгдсэн өртгийн албан татварын e.barimt.mn Цахим хуудсанд бүртгүүлж, хэрхэн ашиглах талаар зөвлөгөө өгч, үйлчлүүлж буй байгууллага, аж ахуйн нэгжээс заавал баримтаа авч байх талаар зөвлөгөө өглөө.

Татвар төлөгчдийн өдрүүд арга хэмжээг “Татвар төлөгч танд баярлалаа-2016” уриан дор зохион байгуулж, ерөнхий боловсролын сурагчдын дунд Татвар төлөгч танд баярлалаа сэдэвт гар зургийн болон зохион бичлэгийн уралдаан зарлаж, татвараа үнэн зөв тодорхойлж, цаг хугацаанд нь төлдөг аж ахуйн нэгж, байгууллагуудыг Гааль татварын ерөнхий газрын талархал, өргөмжлөлөөр шагнаж урамшууллаа.

### **7.Орхон сум:**

Тус сумын Засаг даргын 2013 оны А/28 тоот захирамжийн хүрээнд жил бүр зохион байгуулагддаг Төрийн албан хаагчидтай уулзах мэдээллийн цагийг сумын Засаг даргын Тамгын газраас 2016 оны 5-р сарын 5-ны өдөр зохион байгуулж, төрийн албан хаагчдад Сонгуулийн тухай хууль, Тариалангийн тухай хуулийн сургалтыг зохион байгуулж, орон нутгийн татварын бүрдэлт болон орон нутгийн хагжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй ажлуудын талаар мэдээллүүдийг хүргэж төрийн албан хаагчдын мэдлэг сорих тестийн шалгалтыг авч нийт 58 төрийн албан хаагчийг хамрууллаа.

Сумын Засаг даргын 2016 оны А/02 тоот захирамжийн хүрээнд зохион байгуулагдаж буй “Байгууллага сурталчилах аян”-ы арга хэмжээг сумын Засаг даргын Тамгын газар тайлант сард зохион байгуулж, тус арга хэмжээгээр салбартаа мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм журмын талаарх мэдээллийг багтаасан гарын авлага бэлтгэн иргэдэд тарааж, мөн төрийн үйлчилгээг ард иргэдэд хүргэж буй төрийн албан хаагчдын ажил үйлчилгээтэй холбоотой сэтгэл ханамжийн судалгааг 79 иргэнээс авч, нийт хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг хүргэлээ.

Аймгийн Засаг дарга С.Бүрэнбат 05 дугаар сард Орхон суманд ажиллаж Мангирт, Гүнгуу, Шийр, 42-р зөрлөг, Агьтын хошуу, Арбулан, сумын төвийн чиглэлийн ард иргэд, малчидтай уулзаж цаг үеийн талаар мэдээлэл хийж, малчдад тулгамдаж буй бэлчээр, зуслангийн газрын асуудлыг газар дээр нь шийдвэрлэлээ.

Сумын Засаг даргын 2016 оны А/79 тоот “Тариалангийн талбай, өвөлжөөний газрыг малын хөлөөс чөлөөлөх тухай” захирамжийн дагуу 2016 оны 5-р сарын 10-наас 10-р сарын 10-ныг хүртэлх хугацаанд үр тариа, төмс хүнсний ногооны талбай, өвөлжөөний газрыг малын хөлөөс чөлөөлөх мэдэгдэлийг 154 малчин мал бүхий

өрхөд тарааж гарын үсэг зуруулж баталгаажуулан, хэрэгжилтийг хангангаагүй малчин өрхүүдэд хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллалаа.

#### **8.Сүхбаатар сум:**

Аймгийн засаг даргын 2016 оны А/81 тоот захирамж, Сүхбаатар сумын Засаг даргын 2016 оны А\52 тоот захирамжаар 1-р ээлжийн цэргийн жинхэнэ албаны татлага Шаамар сумын Дулаанхан тосгонд 2016 оны 05 сарын 09-ний өдөр зохион байгуулагдаж, Сүхбаатар сумын 18-25 насны цэргийн жинхэнэ албанд татагдаж зарлан дуудах хуудас авсан залуучуудыг эрүүл мэндийн үзлэгт хамрууллаа.

2016 оны 05 дугаар сарын 14-ний бүх нийтээр мод тарих өдөр Сүхбаатар сумын хэмжээнд 641 өрх 2466 ширхэг мод, аж ахуйн нэгж байгууллагууд энэ жил 2796 ширхэг мод тарьж, өмнөх жил тарьсан 5904 модонд арчилгаа хийлээ.

Тус сумын Засаг даргын ивээл дор ерөнхий боловсролын 4-р сургуулийн нэрэмжит “Сэтгэмж” уран зургийн уралдааны арга хэмжээг иргэд, хүүхэд, мэргэжлийн багш нарын дунд 3 дах жилдээ зохион байгууллаа.

“Дэлхийн гэр бүлийн өдөр”-ийг сурталчлах, гэр бүлийн үнэ цэнэ бахархалт зүйлсийг залуу хойч үеийнхэнд ойлгуулах ажлын хүрээнд 2016 оны 05 сарын 16-ны өдөр Партизаны талбайд Сүхбаатар сумын нийт 160 өрхийн гишүүдийг хамруулсан хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгууллаа.

#### **9.Цагааннуур сум:**

Тус сумын Засаг даргын Тамгын газраас “Улсын тэргүүний сум”-ын шагнал 100.0 сая төгрөгөөр төр, төсвийн байгууллагуудад хийж буй хөрөнгө оруулалтын авто машин, тоног төхөөрөмж, техник хэрэгслийг хүлээлгэн өгөх арга хэмжээг 2016 оны 05 сарын 17-нд зохион байгууллаа. Энэхүү хөрөнгө оруулалтаар Цагдаагийн алба, Эрүүл мэндийн төвд дуудлагын PRIUS 20 авто машин, Спорт цогцолборт бялдаржуулах төхөөрөмжүүд, хүүхдийн цэцэрлэгт шинэ тоглоом, зурагт, Соёлын төвд хөгжим, техник хэрэгсэл болон номын санд шинэ ном, ерөнхий боловсролын бүрэн дунд сургуулийн 19 ангид 44 инчийн шинэ телевиз зэргийг хүлээлгэн өглөө.

Цагааннуур сумын Засаг даргын Тамгын газар, Ерөө сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчид 2016 оны 05 сарын 13-ны өдөр тус байгууллагын үйл ажиллагаатай танилцан, харилцан туршлага солилцлоо.

Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн улсын үзлэгийг 2015 оны 05 дугаар сарын 18-20-ний өдрүүдэд зохион байгуулж, нийт 541 тээврийн хэрэгсэл оношилгоонд хамрагдан 20.0 гаруй сая төгрөгийн орлого төвлөрүүлээ.

Аймгийн сум дундын 20 дугаар шүүхээс иргэд, ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад 2016 оны 05 дугаар сарын 24-ний өдөршүүхийн үйл ажиллагааны талаар болон хууль сурталчилах ажлын хүрээнд сургалт зохион байгуулж, гарын авлага тарааж, шүүхийн ил тод байдал самбарыг суманд хүлээлгэн өглөө.

#### **10.Хүдэр сум:**

Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Малчид, тариаланчдын зөвлөгөөн”-ийг зохион байгуулж, малчид, тариаланчдын төлөөлөл нийт 96 иргэн орцолцлоо. Зөвлөгөөнөөр 2015 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, 2016 онд хэрэгжүүлэх ажил арга хэмжээний талаарх мэдээлэл, Төрөөс хөдөө аж ахуйн талаар баримталж буй бодлого шийдвэрүүдийн талаар мэдээлж, хурдан морь унаач хүүхдийн аюулгүй байдлыг хангах талаар сонсгол хэлэлцүүлэг хийн, малчид, тариаланчид, багийн Засаг дарга нарын гурвалсан гэрээг хэлэлцэн байгууллаа.

Тус сумын Засаг даргын Тамгын газраас “Хүлээж биш хүрч үйлчилье” сэдэвт 7 хоногийн аяныг өрнүүлж, нийт 70 гаруй иргэнийг хамрууллаа. Тус аяны хүрээнд Нийтийн сонсголын тухай хууль, иргэний бүртгэл, эд хөрөнгийн бүртгэлийн талаар, Хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс хэрэгүүлж байгаа төсөл хөтөлбөр, Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Эрүүл

мэндийн даатгалын тухай хуулиар иргэдэд мэдээлэл өгч, 250 гаруй гарын авлага материалыг бэлтгэн тараалаа.

“Халуун сэтгэл” сайн үйлсийн аяныг Түшиг сумын хэмжээнд зохион байгуулж, төр төсвийн байгууллагын ажилчид албан хаагчид идэвх санаачлагатай оролцон, Засаг даргын Тамгын газраас 170.0 мянган төгрөг, ерөнхий боловсролын сургуулиас 483.5 мянган төгрөг, Соёлын төвөөс 30.0 мянган төгрөг, Цэцэрлэгээс 90.0 мянган төгрөг, Эрүүл мэндийн төвөөс 56.0 мянган төгрөг, иргэдээс мод модон материалын дэмжлэг, 2100.0 мянган төгрөгийн эд материалыг хандивлалаа.

#### **11.Түшиг сум:**

Тус сумын Засаг даргын Тамгын газраас олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан “Гэр бүлийн сүүтэй өдөр” арга хэмжээг зохион байгууллаа. Уг арга хэмжээний хүрээнд сумын ахмад настан Б.Чулуунбатын гэр бүлд “Гэр бүлийн уулзалт”-ыг зохион байгуулж, залуу үеийнхэнд ахмад үеийн сургаалийг сонсгох, гэр бүлийн үнэ цэнийг мэдрүүлэхийг зорилоо. Мөн “Аав, ээж, би” хөгжөөнт буухиа тэмцээн, “Гэр бүлийн аз жаргал”, “Манай гэр бүл” сэдэвт эссэ бичлэгийн уралдааныг тус тус зохион байгууллаа.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн дагуу 2016 оны 05 сард нийт 75 иргэнд 25.39 га буюу 203185600 төгрөгийн үнэ бүхий газрыг нэг удаа үнэгүйгэр өмчлүүллээ.

Мал сүргийг халдварт, паразиттахөвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажлыг тус суманд үйл ажиллагаа явуулж буй “Номтын өндөр”, “Хонгор овоо”, “Мөнх Зэлтэр” Мал эмнэлэг үржлийн нэгжүүд технологит хугацаандаа шөвөг, ярын вакцин 1800 толгой үхэрт, цусан хавдар 1200 үхэр, шалзуу 300 нохойд гахайн мялзан 400 толгой гахайд, 20882 толгой богт туулгалт хийгдсэн байна.

#### **12. Шаамар сум:**

Тус сумын газар тариалангийн үйлдвэрлэлийн ажил хаврын тариалалтын бэлтгэл ажил бүрэн хангагдан, Дугуйт трактор 3 үр тарианы үрслэг8, төмсний үрлэгч6, анжис8 бусад техникийг засварлаж хаврын тариалалтанд орууллаа. Хаврын тариалалтанд 3 аж ахуй нэгж 400 гаруй иргэн гарч Үр тариа 568 га, төмс 49 га, хүсний ногоо 72 га талбайд тариалалт хийгээд байна. 94 га талбайг эрдэс бордоогоор бордож 390 га талбайд тарихын өмнөх хөрс боловсруулалт хийгээд байна.

Дулааны улиралын үед төв суурин газар болон гэр хороолол зуслангийн айл өрх байгууллагын стандартын шаардлага хангаагүй ариун цэврийн байгууламж /нүхэн жорлон бохир усны цооног / хэт дүүрснээс үүдэж хүн амд халдварт өвчин тархах, эрүүл ахуйн бохирдлын эрсдлээс урьдчилан сэргийлэх талаар иргэдэд сургалт зохион байгууллаа.

Тус сумын Засаг даргын Тамгын газраас сумын хэмжээнд хэмжээнд халдварт, гоц халдварт өвчин гарах, тархалтаас урьдчилан сэргийлэх, хог хаягдал өтөг бууц хашаа саравч сэг зэм, уст цэгийн ойр орчныг цэвэрлүүлэх ажлыг зохион байгуулж ажиллалаа.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж байгаа 4 өрхийн гишүүн-иргэдэд, Монгол улсын Хүн Амын Хөгжил, Нийгмийн хамгааллын сайдын 2016 оны А/12-р тушаалын дагуу аймгийн Нийгмийн даатгалын хэлтэсээс Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг үнэ төлбөргүйгээр хамрууллаа.